



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 30 өдөр

Дугаар А/563

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор тэдний нийгмийн оролцоог сайжруулах, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн олон улсын өдрийг угтаж зохион байгуулах сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлуудыг зохион байгуулах, төрийн үйлчилгээний байгууллагуудад тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан үйлчилгээг бий болгох чанарын үйлчилгээг нэвтрүүлэх зардалд 15 000 000 төгрөг зарцуулсугай.

2.Дээрх үйл ажиллагаанд шаардагдах 15 000 000 /Арван таван сая / төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангийн төсөл арга хэмжээний 5.19-д тусгагдсан “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, хамгааллыг сайжруулах” дэд хөтөлбөрийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/ -д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Б.Даваадорж/-д үүрэг болгосугай.


ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/563 Ch

02 02526

Аймгийн Засаг даргын 2020 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн А/563 дугаар захирамжийн хавсралт



д/д	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт өртөг
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах олон улсын өдрийн спорт, өдөрлөгийн арга хэмжээ	Хүн	200	10 000	2 000 000
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн Үндэсний холбооны аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих- Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	Хүн	100	10 000	1 000 000
2	Хараагүйчүүдийн аймгийн холбооны үйл ажиллагааг дэмжих- Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах	Хүн	100	18 000	1 800 000
3	Сонсголгүй иргэдийн холбооны аймгийн салбар зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих- Сургалт, зөвлөгөөн зохион байгуулах- /Бүх үйл ажиллагааны дохионы хэлний орчуулгатай явагдана/	Хүн	50	30 000	1 700 000
4	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг эхийн холбооны аймгийн зөвлөл-Сувилал, сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах	Хүүхэд	200	15 000	3 000 000
5	төрийн үйлчилгээний байгууллагуудад тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан үйлчилгээг бий болгох чанарын үйлчилгээг нэвтрүүлэх орчин бүрдүүлэх, сургалт зохион байгуулах	8 байгууллага	8	625 000	5 000 000
6	Дохионы хэлний сургалтын төлбөр	Хүн	1	500 000	500 000
	Дүн				15 000 000